

Д.БОДООГИЙН ТУХАЙ БОДОЛ ЭРГЭЦҮҮЛЭЛ

З.Лонжид

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

Эхлэл

1922 оны VIII сарын 30-31-нд шилжих шөнө Нийслэл Хүрээний зүүнтээ орших Шар хаданд Ардын намын анхны долоогийн нэг-лам, зохиолч, сэтгүүлч, багш, ерөнхий сайд, Гадаад яамны сайд асан Д.Бодоог 14 хүний хамт төрийн цаазаар хороож, тус улсын ардын засаг улс орноо удирдсанаас хойш анх удаа "Төмөр нүүр"-ээ харуулж, буруу үзэлт хэн боловч ийм цээрлэлд заавал өртөнө шүү хэмээн өргөн олонд сургамж үзүүлжээ.

Энэ хэрэг "хэрхэн" үүдсэн, түүний чухам учир юу болохыг 1989 оноос хойш судлаачид, хууль хяналтын албад нягтлах болсон юм. Харин түүнээс өмнө буюу 1922-1988 онд өөрөөр хэлбэл, 70 шахам жилийн хугацаанд "Бодоо бол хувьсгалын эсэргүү байсан юм" гэдэг номлолыг ямагт ухуулан сануулж, түүх шастирт жигшин тэмдэглэсээр байв. Азаар ардчилал шинэчлэл тууштай хэрэгжиж ил тод байдал, олон ургальч үзэл чөлөөтэй болсны үрээр Д.Бодоо агсныг нэхэн цагаатгасан билээ. Үүнээс хойш манай зарим түүхчид түүний тухай бүтээл зохиол туурвиж байгаа боловч даацтай судалгаа одоогоор алга байна. Иймд тэр их хүний тухай өөрийн бодол эргэцүүллээ судлаачидтай хуваалцъя хэмээн сэтгэл шулуудаж үүнийг тэрэллээ.

Бодоогийн тухай үүвэр түүвэр мэдээ

Аливаа улс төрийн зүтгэлтнүүдийн намтар, үйл ажиллагааг сонирхон судлаачид тухай хүний зүс царай, дуу хоолой, биеийн галбир төрхийг тодорхой өгүүлсэн нь цөөнгүй байдаг. Харин Д.Бодоогийн тухай ийн дурсах зүйл ховор бололтой. Партизан Далхын Эндэнданзан агсны өөрөө бичсэн нэгэн дуртгалд өгүүлснээр бол тэрбээр өндөр нуруу, шонхор хамар, шар царай, хөнхөр нүдтэй учраас түүнийг зарим хүмүүс Орос Бодоо "Оросын нууц хүү" хэмээдэг байсан ба огцом түргэн зантай гомдох, баярлах нь амархан хүн байсан аж. (15.3)

Энд зориуд дурдах нэг зүйл бол эрдэмтэн Г.Дэлэг 1950-аад оны сүүлч 60-аад оны эхээр Д.Эндэнданзантай хэд дахин уулзаж түүнээс олон зүйл лавлаж магадласны дотор Д.Бодоотой холбогдох нилээд мэдээ тодруулсан нь эх түүхийн судалгаанд зохих ёсны тус дэм болж байна. Эндэнданзангийн ярьснаар бол Монголын сонин сэтгүүлүүдэд нэр гардаг Болд-Илд гэдэг нь "Д.Бодоогийн зохиомол нэр" (8.139) байсан бөгөөд Ж.Цэвээн, гүн Бадрахбаатар нар "Шинэ толь хэмээх сонин бичиг"-т өөр өөрсдийн бичдэг тусгай сэдэвтэй байсан гэнэ. Жишээлбэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, томоохон нийтлэл, орчуулгын зохиолыг Ж.Цэвээн, шүүмжлэлт өгүүлэл иргэний нийтлэлийг Д.Бодоо, засгийн газрын мэдээ сонсгол, Улсын дээд доод хурлын холбогдол бүхий сурвалжлага, сонсголыг Шүүх Таслах Яамны түшмэл Жанцансамбуу нар бичдэг байжээ.

Хиагтад төрж хорин хэдэн нас хүртлээ тэнд сууж, 1921 онд нутгийнхаа үйлчин бүсгүйчүүдтэй хамт журамт цэргийн майхан, туг, хиур оёлцож явсан боловч төрсөн эцэг нь хятад байсны улмаас партизан болж чадаагүй авч хожим нь хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн цол хүртсэн Должингийн Мядагмаа хэмээх буурал 1993 онд Д.Бодоогийн зүс царай, төрх галбирын тухай ярихдаа Эндэнданзангийн дурсан бичсэнтэй төстэй зүйл өгүүлж, харин Д.Бодоо сайдын нуруу тийм ч цэх бус сэрвээгээрээ бага зэрэг бөгтөр, өр сахалгүй, яару сандруу зантай, монгол бичгийн дармал үсэг сайхан бичдэг, бараг хүн бүхнийг "та" гэж дууддаг хэнтэй ч яриа хөөрөө өрнүүлж байнга хүний нүд рүү эгц харж ярьдаг сонин хүн байлаа гэж өгүүлсэн юм. (7)

Мөн Хиагт Сэлэнгийн уугуул Найдангийн Дулмаа хэмээх хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн буриад эмгэн Д.Бодоогийн царай зүс зан ааш галбир төрхийг дээрх хүмүүсийн адил тодорхойлоод тэрбээр морь унахдаа дөрөөн дээрээ босоо явдаг, ер нь моринд тийм ч сайн биш байсан шиг санагдаж байна гэж хуучилсан юм. (14)

Ээндэнданзангийн дуртгалд Д.Бодоогийн өргөмөл эх Цэрэндулам чавганцынх тун ч ядуу Х.Чойбалсан бид хоёрын махан захаас олж ирсэн цувдай, толгой шийрээр амттай хоол хийж бидэнд өгдөгсөн хэмээн бичжээ. Мөнөөх Д.Мядагмаагийн өгүүлснээр бол Д.Бодоогийн гэргий Янжин гэж байсан ба тэднийх хөрөнгө хогшил тун тааруухан үр хүүхэдгүй маш олон хүн орж гардаг хөл ихтэй айл байлаа. Бодоог цаазалснаас хойш хэдэн оныг тодорхой санахгүй байна Янжин гуай Сангийн Яамны Очир гэгчтэй ханилсан боловч 1930 оны орчим Очир баригдаад сураггүй болсон. Түүнээс хойш Янжин гуай таньдаг хүмүүсээсээ байнга дөлж зугтаад байдаг яг халз тулаад уулзахад газар ширтээд бараг юм ярьдаггүй болчихсон байсан. Чойбалсантай нэг үе ханилж байсан Цэвээнжалбын Бортолгой над ярихдаа Янжин зүүлэг өвчтэй болсон юм шиг байна лээ гэж байж билээ. 1932 оны үеэс л Янжин гуай хотод ер үзэгдэхээ байсан бодоход өвчин хууч нь ужигарч хэвтэрт орсон уу, эсвэл Манзуширийн хийд, Гавжийн шанд хавьд байсан өөриинхөө садангийнх руу явсан уу ямар ч байсан сураггүй л болсон гэж хуучилсан юм. (7)

Жич: Д.Бодоогийн ердөө хоёрхон фото үлдсэн байх бөгөөд тэр нь хүмүүстэй цуг авхуулсан малгайтай зураг болохоор түүний нүүр царай биеийн төрхийг сайтар тодорхойлох боломжгүй мэт.

Д.Бодоо ба эх түүхийн судалгаа

1922-1989 он хүртэлх хугацаанд Д.Бодоогийн тухай үнэн үг хэлчих “зүрх зоригтой” хүн тун ховор байв. Энэ нь үзэл суртлын чанд заавар зөрчсөн хэн боловч эсэргүү тэрс үзэлтэн болж, янз бүрээр хохирдог байсны уршиг мөн. Гэвч 1921 оны монголын үндэсний ардчилсан хувьсгалын үүсэл, өрнөл ялалтын тухай ямар ч сэдвийг Д.Бодоогоос салангид өгүүлэх боломж байгаагүй юм. Тиймээс судлаачид түүний үйл ажиллагааны зарим хэсгийг арга буюу цухас боловч дуудаж байлаа. Жишээлбэл, 1920-иод онд түүхч Магсар хурц өөрийн бүтээлдээ Д.Бодоогийн тухай хэдийгээр товч боловч үнэнээр нь өгүүлсэн байдаг. Тухайлбал* 1921 оны 7-р сарын 8-нд Ардын Түр Засгийн Газрын эрх баригчид Нийслэл Хүрээнд ирээд Богд хаантнаа бараалхахад Д.Бодоогийн хэлсэн үгийг эш татан бичжээ. Тэрбээр хэлсэн үгэндээ **“Бидний ардын төлөөлөгчдөөс Богд хаан болон олон лам ноёд та бүхний сануулсан ёсоор Их Орос Улсын тусламжийг олж гадаадын харгисыг сөнөөж, газар орноо бүрэн бүтэн болгон авав.”** (10.217) гэж онцлон тэмдэглээд Монголд барон Унгерний явуулж буй үйл ажиллагааны тухай шинээр байгуулах төр засгийн хэлбэрийн тухай үргэлжлүүлэн илтгэж, үгийнхээ төгсгөлд **“Богдыг хэмжээтэй эзэрхэх хаанд өргөмжлөн ардын эрхт засгийг нэгтгэн байгуулах болно”** (10.217) гэжээ. Мөн 1921 оны зун Монголын байнгын Засгийн Газар эмхлэн байгуулахад Д.Бодоо хамгийн гол үүрэг гүйцэтгэсэн хүн гэдгийг Магсар хурц цохон тэмдэглээд тэрбээр тухайн үедээ Монголын төр засгийн бодлого боловсруулах тулгамдсан зорилтыг онож шийдвэрлэхэд томоохон үүрэг гүйцэтгэснийг үнэмшилтэй өгүүлсэн байна.

Үүнтэй холбогдуулж тэмдэглэхэд Магсар хурц 1921 оны зун Ардын Түр Засгийн Газар, МАН-ын удирдах хүмүүс Нийслэл Хүрээнд анх орж ирснээс эхлээд 1922 оны намар Д.Бодоог цаазлах хүртэл Засгийн Газрын гишүүн, Шүүх Таслах Яамны тэргүүн сайд байсан учраас тэр үеийн Монголын төр засгийн ажил хэргийг сайтар мэддэгийнхээ хувьд ийнхүү тодорхой бичсэн буй за. Иймээс Д.Бодоогийн удаа дараа бичсэн захидал, тавьсан илтгэл хэлсэн үгийн ихэнх нь эдүгээ бүрэн олдоогүй байгаа учраас Магсар хурцын бүтээлдээ дурдан

тэмдэглэснийг эх баримт, анхдагч сурвалж хэмээн ашиглах боломжтой мэт. Миний санахад Магсар хурц Д.Бодоогийн тухай ямар нэгэн зүйлийг аль нэг тийш нь хэтрүүлж буюу зохиож, нэмж, чимж бичээгүй байх. Яагаад гэвэл 1925 онд тэрбээр номоо бичиж байх үед түүхийн амьд гэрч болох олон хүн ялангуяа Ардын Намын анхны долоогоос Х.Чойбалсан, Д.Догсом болон Д.Бодоотой холбоотой зүйлийг сайн мэдэх түшмэл Цэрэн-Очир зайсан, Ж.Цэвээн, Эрдэнэбатхаан, Жамъян-Очир, Буянчуулган, Манзушир хутагт Цэрэндорж зэрэг хүмүүс бүгд эсэн мэнд байсан билээ. Тиймээс тэрбээр Д.Бодоогийн тухай үнэнийг өгүүлсэн байх нь мэдээж.

1930-аад оны эхээр МАХН-ын түүхийг дэлгэрэнгүй байдлаар боловсруулж бичих үүрэгтэй олон хүн оролцсон комиссын гишүүн С.Буяннэмэхийн бичсэн зүйлд Д.Бодоо бол МАН-ыг анхлан байгуулагчдын нэг, төрийн зүтгэлтэн хэмээсэн санаа тэмдэглэсэн байдаг. (9.1-6-118.21-22 дахь талд үз.)

1934 онд Х.Чойбалсан бусад хүмүүстэй хамтран бичсэн бүтээлдээ Д.Бодоогийн тухай олон зүйл дурсан тэмдэглэсний дотор 1920 оны намар тэрбээр Эрхүүгээс Монголд буцаж очоод барон Унгөрний цэрэгт “элсэж” нилээд хэдэн сар болохдоо цагаантны гол зорилго бол **“Монголын хүчийг хэрэглэж ЗОУ ба МАН-тай эсэргүүцэн байлдах”** явдал байсныг ойлгож мэдснээ 1921 оны III сард Хиагтад очоод Д.Сүхбаатар над ярьж байлаа хэмээн тэмдэглэсэн нь судлаачдын сонирхлыг ихээхэн татдаг. Уул бүтээлд Д.Бодоогийн тухай өгүүлэхгүй байх арга байсангүй, гэвч Д.Бодоод шууд холбогдох зарим зүйлийг зориуд засварлаж бичжээ. Жишээлбэл: өмнө дурдсан 1921 оны VII сарын 8-нд Ардын Түр Засгийн Газрын тэргүүлэгчид Богд эзэнд бараалхахад “Их жанжин Сүхбаатар Д.Бодоогийн хамт шууд олон сайд, лам, ноёдын хуралдан байгаа Цэргийн Яамны Газар ирж анх удаа илтгэсэн үгийн” (17.252) товч хэмээн мөнөөх Магсар хурцын бүтээлд бичсэн Д.Бодоогийн үгийг яг хэвээр нь хуулбарласан байлаа.

1960-1962 онд академич Д.Төмөр-Очирын удирдсан комиссын бэлтгэсэн МАХН-ын түүх зохиолд Д.Бодоо, С.Данзан нарыг Монголын хувьсгалын удирдагчид байсан хэмээн нилээд тодорхой өгүүлж, тэдний үйл ажиллагааг бодитойгоор үнэлсэн байлаа. Харамсалтай нь тэрхүү үнэлэлт, дүгнэлт тухайн үеийн нам, төрийн удирдах тушаалтан олон хүний үзэл баримтлалд нийцээгүйн улмаас Д.Төмөр-Очирыг үзэл бодлын хувьд буруутгахад хүргэсэн байж магадгүй.

1954 оноос эхлэн 1985 он хүртэлх хугацаанд Монгол, Зөвлөлтийн эрдэмтдийн хамтран боловсруулсан ба манай түүхчдийн дангаараа бичсэн “БНМАУ-ын түүх” нэг боть, олон боть зохиолуудад болон 1963-1985 онд гурван удаа хэвлэсэн “МАХН-ын товч түүх”, “Монгол Зөвлөлтийн харилцааны түүх” зэрэг нэр хүндтэй хэд хэдэн бүтээлд Д.Бодоог эсэргүү этгээд гэдэг сөрөг байр сууринаас яг ижил өнгө аястай тайлбарлаж байлаа. Ер нь 1989 оноос өмнө “Эсэргүү” Д.Бодоогийн тухай судлах нь “цээртэй” байсан учраас жирийн иргэд, оюутан, сурагчид түүний тухай ямар ч үнэн мэдлэггүй байсан төдийгүй зарим түүхчид Д.Бодоо чухам хэзээ ямар хэргээр цаазлагдсныг тойм төдий гадарладаг байлаа. Тиймээс ч 1974 онд “Монгол Зөвлөлтийн харилцаа” хэмээх баримт бичгийн эмхтгэлд өгүүлэхдээ Д.Бодоо 1918-1919 оны үеэс буюу **“хувьсгалт бүлгэмийн үйл ажиллагаанаас эхлэн дараа нь МАХН байгуулагдснаас хойш ч хувьсгалын түр зуурын хань байсан учраас туйлбаргүй, бөөрөнхий, бялдууч байдал удаа дараа гаргаж Богд эзэнт төрийг сэргээн мандуулснаар хувьсгалын зорилтыг хязгаарлаж, ямар нэгэн хувьсгалт өөрчлөлт хийхгүй байх гэж оролдож байжээ”**. (11.563) Тиймээс ч тэрбээр хувьсгал ялсны **“дараа илт хувьсгалын эсэргүү бодлого баримталж Богд гэгээнийг тойрон хүлээлэсэн шашны харгис толгойлогчидтой нягт холбоотой байсан учир 1922 оны эхээр Засаг Төрийн бүх албан тушаалаасаа зайлуулагдаж, МАХН-ын Төв Хорооны бүрэлдэхүүнээс**

хасагджээ. Д.Бодоо хувьсгалаас урван тэрсэлж, ардын засгийн эсрэг хуйвалдааныг өөгшүүлэн зохион байгуулагч болж Япон болон Жан-Зо Линтэй холбоо тогтоожээ." (11.563) Д.Бодоо нарын 15 хүнийг 1922 оны IX сарын 10-нд, Д.Чагдаржавыг мөн оны X сарын 10-нд тус тус цаазалжээ хэмээн тэрхүү номонд өгүүлснээс үзэхэд Д.Бодоогийн тухай тун ч хомсхон мэдлэгтэй хүн түүнийг бичсэн нь илэрхий байна.

Монголын түүх судлалд Д.Бодоогийн тухай ймэрхүү байдлаар бичиж байсны нөлөөгөөр түүнийг уран зохиол, тайз дэлгэцийн урлагт хэзээний бүтэлгүй, хорон санаатай гуйвж дайвсан Хүрээ- Манзуширын хийдийн хооронд давхисан асман лам байсан гэдэг хэвшмэл дүрээр харуулах болсон нь олны сэтгэлд тэр хэвээрээ хоногшжээ.

Монголын нам, төрийн удирдагчид өндөр албан тушаалтнуудын олонх нь зүүнтний их хийрхэл газар авсан 1929 оноос эхлэн бүхнийг мэдэгчийн дүр эсгэж эсэргүү хэмээн гүтгэлгийн хар дансанд бичүүлсэн бараг бүх хүнийг элдвээр гүтгэж, үгийн муугаар зүхэж хараан "ясыг нь өндөлзүүлэх" болсон юм. Ө.Бадрах МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга байхдаа бичсэн хоёр боть том зохиолдоо Д.Бодоо, С.Данзан, Ц.Дамбадорж, Н.Жадамба, Г.Гэлэгсэнгэ, Ж.Цэвээн нарыг газар дор ортол нь муулж Д.Бодоо бол бүр 1920 онд МАН хэмээх хувьсгалт нууц байгууллагын үеэс л эсэргүү байсан юм шиг ойлгоц төрүүлэхийг хичээсэн байдаг. (2.12-40 дэх талд үз).

Ер нь 1990 оноос өмнө өндөр албан тушаалтай байсан хүмүүс бараг бүгдээрээ ёс мэт өмнө дурдсан "эсэргүү" нарын тухай өөрсдийн илтгэл хэлсэн үг, бичсэн өгүүлэлдээ заавал нэхэн шүүмжилдэг "зуршил"-тай байлаа. Харин Монголын төрийг 10 гаруй жил тэргүүлсэн Ж.Самбуу тэдгээр "эсэргүү", баруунтан, зүүнтэн нарыг төдийлөн харааж зүхээгүй чимээгүй өнгөрсөн байдаг нь тэр өвгөн хэн байсныг харуулж байх мэт.

Ардчилал, шинэчлэл, ил тод байдал эргэлт буцалтгүй хэрэгжих болсны үрээр 1990 оны хавраас эхлэн янз бүрийн хүмүүс ялангуяа сэтгүүлчид, түүхчид Д.Бодоогийн тухай сонирхож, 1990 онд доктор Лха.Бат-Очир Д.Бодоогийн тухай бэсрэг зохиол бичсэн (3) ба төвийн хэвлэлд хэд хэдэн өгүүлэл нийтлэгдсэн юм. Гэвч 1991 оны V сарын 6-наас 1996 оны сүүлийн хагас хүртэлх хугацаанд Д.Бодоогийн "гэмт хэрэг"-ийг Монгол улсын прокурор, Дээд шүүхээр хоёр удаа хэлэлцээд цагаатгах боломжгүй хэмээн буцаасан явдалд олон түмэн нилээд эргэлзэж, зарим судлаач, сэтгүүлч Д.Бодоогоос холхон байсан нь аминд өлзийтэй юм шиг байна, Зөвлөлтийн нарийн мэргэжлийн хуульч түүнийг байцааж гэм буруутайг нь нотолсон юм байна" хэмээн ярьж, хэлж болгоомжилсоор байв. Зарим албан тушаалтнууд Д.Бодоогийн хэрэг бол хойт их хөршийн эсрэг чиглэсэн учраас Монгол, Зөвлөлтийн харилцаанд ямар боловч хамаатай, тиймээс түүний хэргийг цагаатгах шаардлагагүй гэсэн байр суурьтай байлаа. Гэвч цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комис болон "зарим иргэдийн хүсэлтээр Улсын Дээд шүүхээс түүний хэргийг дахин шалгуулахаар Улсын прокурорт ирүүлсэн учир 1995 оны I сарын 16-ны өдрөөс эхлэн Тагнуулын төв газар (тухайн үеийн нэрээр. З.Л) (13) түүний хэргийг нэхэн шалгаж, гэмт хэрэгтэн хэмээн нотлох зүйл олоогүйгээ холбогдох байгууллагуудад албан ёсоор мэдэгдсэний дараа 1997 оны VI сарын 11-нд УДШ-ийн хяналтын шатны хуралдаанаар Д.Бодоо нарын 15 хүний хэрэг гэгчийг гэмт хэргийн бүрэлдэхүүн нотлох баримтгүй гэдэг үндэслэлээр цагаатгажээ. (18) Энэ бол "үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцнэ" гэдгийн нотолгоо боллоо.

Үүнээс хойш олон хүн Д.Бодоогоос айж эмээхгүй байх боломж бүрдэж түүний тухай судалгаа эрчимжих болсон юм. Тухайлбал 2001 онд доктор, проф. Ж.Болдбаатар нарын боловсруулсан "МАХН-ын түүхэн замнал", 2003 онд хэвлэсэн "Монгол улсын түүх" зохиолын 5-р боть ба бусад судлаачдын бүтээлд Д.Бодоогийн тухай зохих үнэлэлт, дүгнэлт өгсөн байна. Мөн доктор Лха.Бат-Очир

абугай Д.Бодоогийн бичгийн өвийг эрж цуглуулан 90 гаруй баримт бүхий эмхтгэлийг 2001 онд хэвлүүлсэн нь орчин үеийн Монголын улс төрийн зүтгэлтний том төлөөлөгч тэр хүний тухай сонирхдог хүмүүс төдийгүй хэн боловч уншиж судлууштай бүтээл болжээ.

Бас 2003 онд доктор, проф Ж.Болдбаатар хэвлүүлсэн нэгэн бүтээлдээ Д.Бодоогийн тухай тусгайлан өгүүлж, тэрбээр **“аху цагийн салхинд автагдсан туйлшрал, эндэгдэл”**-ээс ангид байж чадаагүй боловч **“алдаанаасаа сургамж авч засаж залруулан улам ихийг бүтээхийн төлөө хичээнгүйлэн зүтгэж байсан”** (5.89) боловч түүний өрсөлдөгчид хувьсгалын эсрэг Д.Бодоогийн хуйвалдаан гэгч хэрэг бүрдүүлсний золиос болсныг тэмдэглэжээ.

Д.Бодоог өгүүтгэсний учир юу байсан бэ?

Д.Бодоог улс төрийн эсэргүү гэмт хэрэгтэн хэмээн хилс гүжир хэрэгт түлхэж цааш харуулсан гол шалтгаан гэж заавал байх ёстой. Энэ талаар судлаачид нэхэн үзсэн зүйл ховор бололтой. Иймээс би энэ тухайд өөрийн бодлоо хуваалцахыг хичээлээ. Тэрбээр 1921 оны IV сарын 16-наас 1922 оны II сарын 7 хүртэл 8 сар гаруй хугацаанд Монгол ардын түр ба байнгын Засгийн Газрыг тэргүүлэхдээ улс орноо харийн түрэмгийллээс бүрмөсөн чөлөөлж, тусгаар тогтнолоо олон улсаар зөвшөөрүүлж, Орос, Хятад, АНУ-тай найрсаг, эрх тэгш харилцаатай байхыг тэргүүлэх зорилт болгож, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд нилээд ажил сэдэж, зохион байгуулж үр дүнд хүрч байлаа. Тухайлбал, ДИУ шинэ Монгол улсын тусгаар тогтнолыг огтхон ч хүлээн зөвшөөрөөгүйгээр үл барам цэрэглэн халдаж болзошгүй байсныг Монголын удирдагчид ухааран ойлгож, ЗОУ-ын цэргийг Монголд түр байрлуулах шаардлагатай хэмээн үзэж байв. Иймээс ч Д.Бодоо ерөнхий сайдын хувьд хойд хөршийн зохих байгууллага, эрх мэдэлтэнд албан ёсоор хандаж, уул ажлыг хэрэгжүүлсэн юм. Түүнээс гадна Их Орос Улс бол Монголын мөнхийн хөрш гэдгийг тэрбээр мэдэхийн илүүгээр мэдэж, ойлгож байсан боловч дэлхий дахинаас ялангуяа, том гүрнүүдээс зөвхөн ганцтай нь түншлэж, бусдаас нь хөндийрөн зожирвол эцэстээ нэг улсаас бүх зүйлээрээ хараат дагуул орон болж хувирна хэмээн тэрбээр төсөөлж байсан байж тун магадгүй. Ингэж болгоомжлох шалтгаан ч байсан. Жишээлбэл, ЗОУ ДИУ, Монголын асуудлаар эвсэн зохицох буюу Монголын тусгаар тогтнолын асуудалд хоёрдмол байр суурьтай хандаж орос мэргэжилтэн, зөвлөх, сургагч нар Монголын цэрэг арми, төр захиргааны төв байгууллага, МАН-д байнга сууж, олон асуудлыг онц эрхтэйгээр шийдвэрлэж байсан нь ЗОУ Монголын бүх эрх мэдлийг өөртөө авснаас бараг ялгаагүй байв. Коминтерний суурин төлөөлөгч ЗОУ-аас Монголд суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газрууд тус улсын төр засгийн үйл ажиллагааг чанд хянаж, ялангуяа гадаад харилцааны асуудалд онцгой анхаарч байнга төвдөө мэдээлж байлаа. Тухайлбал, 1921 оны IX сарын 15-нд Коминтерн Монголын тухай мэдээлэл гаргаж **“сүүлийн үед Хаалганд суугаа Америкийн консул нийслэл хүрээнд ирж хувьсгалт Монгол, Хятад улс хоёрын хооронд зуучлах үүргийг өөртөө, өөрөөр хэлбэл Америк улсад авахыг хичээн үнэн худал элдэв юм ярьжээ.”**(11.74) хэмээн онцлон тэмдэглэсэн байх боловч чухам тэрхүү консул Самуэл Сокобин Д.Бодоотой уулзсан эсэх талаар тодорхой зүйл өгүүлээгүй байна. Энэ бол тэр үед Нийслэл Хүрээнд байсан ЗОУ-ын зохих албаны хүмүүс Д.Бодоо С.Сокобин нарын уулзалтыг мэдэж амжаагүйн илрэл бололтой. Гэвч С.Сокобины үйл ажиллагааг ихээхэн хардаж, чухам ямар асуудлаар Д.Бодоотой зөвлөлдсөнийг мэдэх онцгой шаардлагатай байсан ажээ. Иймээс ч шинэ тутам байгуулсан Дотоодыг Хамгаалах Газрын сургагч Матрон Давид Иосифович буюу Андрей Сорокин 1922 оны VIII сарын 5-нд Д.Бодоог анх эхлэн байцаахдаа Америкийн консултай юун тухай ярилцсан бэ гэж асуухад тэрбээр **“би Америкийн консул лугаа ер учирсангүй”** гэж хариулжээ. Д.Бодоо тэрхүү консултай маш нууц байдалд

уулзсан болохоор оросууд түүнийг мэдээгүй хэмээн итгэж байсан учраас тэгж эрсхэн хариулсан бололтой.

Гэтэл С.Сокобин 1921 оны VIII сарын 18-нд Нийслэл Хүрээнд ирж, сар шахам хугацаанд Монголын байдалтай танилцах явцдаа Богд хаантан, Засгийн Газрын бараг бүх гишүүдтэй уулзсанаас гадна Д.Бодоотой хэд хэд уулзаж, ярилцсаныг нотлох бодитой баримт эдүгээ АНУ-д хадгалагдаж байдгийг манай нэг эрдэмтэн олж судалгааны эргэлтэнд оруулжээ. (1)

Д.Бодоо С.Сокобинтэй уулзсанаа нууцалсны учир бол Зөвлөлтийн хүмүүсээс тухайн асуудлаар зөвшөөрөл аваагүйтэй холбоотой байсан байж тун магадаггүй. Д.Бодоо түүнтэй уулзахдаа Монголын шинэ Засгийн газрын хамгийн чухал зорилт бол улсынхаа тусгаар тогтнол бүрэн эрхт байдлыг гадаад орнуудаар хүлээн зөвшөөрүүлэх явдал мөн. Үүнд АНУ тусална хэмээн итгэж байгаагаа тэрхүү консулд мэдэгдэж, уламжилж байсныг Америкийн үндэсний түүхийн архивт байгаа сурвалж нотолж байна. 1921 оны намар Богд хаантнаас АНУ-д хандаж Монгол, ДИУ хоёр “эв найрамдлын” дотор учраа ололцоход туслан зуучлахыг хүссэн захидал бичиж, тэрхүү консулаар хүргүүлсэн байна. Яг тэр үед буюу IX сарын 22-нд Д.Бодоо АНУ-ын гадаад хэргийн яамны сайдад хандаж Монгол улсад элчин суулгаж найрсаг харилцаа тогтоохыг хүссэн албан захидал, мөн дээрх архивт хадгалагдаж буй ажээ. Тэр захидал нь тухайн үед Монголын нэгэн сонинд нийтлэгдсэнтэй үг үсгийн зөрөөгүй ижил байна. (16.1921-08-28) Үүнээс үзвэл Д.Бодоо дээрх албан захидлыг нууцлах шаардлагагүй хэмээн хэвлэлд нийтлүүлсэн бололтой. Тэр захидлыг бичихээс хоёр хоногийн өмнө Д.Бодоо ЗОУ-д хандаж Монгол, ДИУ хоёрын хооронд зуучилж өгөхийг албан ёсоор хүссэн байлаа. Тиймээс яг энэ асуудлаар АНУ-д хандаагүй байна. Харин Богд хаантан Монгол, Хятадын харилцааг хэвийн болгоход туслахыг АНУ-аас хүссэн нь түүний өөрийнх нь шийдэл байсан байж болох юм.

Ийнхүү Монголын эзэн хаан, ерөнхий сайд хоёр АНУ-д найрсгаар хандсан явдалд ЗОУ ихээхэн дургүйцэж байсан нь лавтай. Өөрөөр хэлбэл, Монгол улс дэлхийд нөлөөтэй хүчирхэг том гүрэнтэй ойртож дотносвол ЗОУ-ын Монголд үзүүлэх нөлөө багасах буюу үгүй болохоос Оросын эрх баригчид маш болгоомжилж Д.Бодоог ерөнхий сайдын тушаалаас өөрчилж, улс төрөөс бүр мөсөн холдуулах шаардлагатай гэж үзсэн байна. Үүнээс гадна тэрбээр Монголын төр засгийн тогтолцоог шинээр төлөвшүүлэхдээ **“амар тайван суугаа Англи улсыг өмнөх толь болгож болно.”** (9.4-27,42) хэмээн тууштай итгэж түүнийгээ нэр нөлөө бүхий зарим хүмүүст албан захидлаар мэдэгдэж байв. Өөрөөр хэлбэл, шинэ Монголын засаглалын хэлбэр ЗОУ-тай адил бус хаант засагтай, Англитай адил байхыг Д.Бодоо хичээж байсан явдал тэрбээр хэлмэгдэх бас нэг шалтгаан болсон нь лавтай.

Д.Бодоогийн хариулт өчгийн доторх анхаарууштай нэг мэдээ бол Богд хаантан Д.Бодоод сануулахдаа **“засаг мэдлээ Оросын гарт оруулалгүйгээр Монголчууд өөрөө эрхээ барьж байхыг бодно уу”** (6.124) гэж хэлж байжээ. Үүнээс үзвэл Монголын хэрэгт ЗОУ хэтэрхий гүнзгий оролцож, тус улсын удирдагчдын эрх мэдэл хязгаарлагдаж байсан явдалд Богд хаантан ихээхэн сэтгэл түгшиж байсан нь тодорхой. Иймээс ч эзэн хааныхаа дэмжлэг хүлээсэн Д.Бодоо Оросууд хэт дур зоргоороо аашлахыг бага боловч хязгаарлах үүднээс АНУ-тай ойр дотно харилцаа тогтоох арга зам эрэхэд хүргэсэн байж магадгүй. Энэ явдал Д.Бодоог буруутгах бас нэгэн шалтгаан болсон нь гарцаагүй. Жич Д.Бодоо, С.Данзан хоёрын үзэл бодлын зөрөлдөөн хурцадсаар эцэст нь Д.Бодоо хэлмэгдсэн гэдэг санааг зарим судлаачид дэвшүүлдэг бөгөөд, үүнд үнэний хувь байж магадгүй. Гэвч **Д.Бодоог егүүтгэхэд хүргэсэн гол шалтгаан бол Монголын бүх хэрэг явдалд ЗОУ хэтэрхий оролцож, аливаа асуудлыг өөрийнхөө эрх ашигт захируулан шийдвэрлэхээр санаархах болсныг тэрбээр эрс эсэргүүцэж байсан явдал юм.** Ер нь тэрбээр Монгол улс гадаад

харилцаагаа аль болох өргөтгөх ялангуяа АНУ-тай бүх талаар түншлэх нь Монголын хувь заяанд эерэг үр дүнтэй гэдэгт тууштай итгэж байсан явдал эцэстээ түүний амь насанд хүрсэн нь дамжиггүй буй за.

Д.Бодоогийн дурсгалыг мөнхжүүлж болох уу?

Эрх бүхий байгууллага Д.Бодоогийн хилс хэргийг цагаатгаснаа зарласнаас хойш багагүй хугацаа өнгөрлөө. Гэвч түүний тухай судлаачид мэр сэр бүтээл туурвиж байгаа боловч төр засгаас гавъяа зүтгэлийг нь мөнхжүүлэх талаар сэдэж санаачилсан зүйл ер алга. Д.Бодоогийн ах дүү, төрөл садангийн хүн гэж одоо ер байхгүй бололтой. Энэ нь түүнийг цаазлуулснаас хойш ойр төрлийнхөн нь эсэргүүний хамаатан садан хэмээн нүд үзүүрлэгдэхээс болгоомжилсонтой холбоотой байх. Түүнээс биш тэрбээр бусдын адил мах цусанд төрсөн хүмүүн болохоор элгэн садантай байсан нь лавтай. Өнөөгийн байдлаас ажихад гавъяат хүмүүсийн үр хойч, ач гуч нар бэл бэнчинтэй бол тухайн хүнээ алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх явдал нилээд түлхүү байна. Үүнийг хэн ч урвуугаар ухах буюу буруутгах хэрэггүй. Харин ч сайшаах нь зөв билээ. Ялангуяа төрийн сан хөмрөг нимгэн байгаа энэхэн зуурын тохиолдолд түүхт хүмүүсийн ой дурсгалыг тэдний үр сад пүүс компанийн тэтгэлэг дэмжлэгээр тэмдэглэхийг төр засаг дэмжин хөхиүлэх нь учир зүйн хэрэг мөн. Гэхдээ Монголын төр засаг шинжлэх ухаан, боловсрол, бусад салбарт гавъяат үйлс бүтээсэн хүмүүсийн дурсгалыг хэрхэн мөнхжүүлж, хойч үедээ тэднийг яаж мэдүүлэх вэ гэдгийг төр засгаас ул суурьтай боловсруулах явдал зайлшгүй шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, урсгалаар буюу цагийн аяс, хэсэг хүний хүсэл, сонирхолд хөтлөгдөж асуудлыг огцом шийдвэрлэж баймааргүйсэн. Ийн хэлэхийн учир гэвэл бид өнө эртнээс эхлэн алдар суутнуудаа үеэс үед дээдэлсээр ирсэн уламжлалаа улам төгөлдөржүүлж, хөлгүй их найр наадам өгөөж багатай хурал зохион байгуулахаасаа ямар боловч татгалзаж, нилээд даацтайхан цогц ажил сэдэж хэрэгжүүлэх цаг болжээ.

Төгсгөл

Улс Монголынхоо төрийн тусгаар тогтнол бүрэн эрхт байдлын төлөө чин санаагаар зүтгэж зорьсон их хэргийнхээ эхний үр шимийг үзсэн боловч, цөвүүн цагийн шуурганд өртөж амиа алдсан Д.Бодоо хэмээх их хүмүүний тухай бид дэндүү бага мэддэг төдийгүй, залуу хойч үе маань түүнийг ор тас мартаход хүрч буй нь даанч харамсмаар. Ер нь бид үе үеийн түүхэн зүтгэлтэн, түүхт хүмүүс алдар суутнуудаа тун ч бага мэдэж байна. Үүнд хэнийг буруутгах вэ хэмээн эрэл хайгуул хийхийн оронд цаашид юу хийх вэ? Төр засгийн бодлого үйл ажиллагаанд яаж тус дэм болох вэ гэдгийг судалгаа шинжилгээний хүрээлэн, төв , их дээд сургууль, музей, урлагийн газрууд , түүхч, улс төрчид, нам эвсэл холбоо, хөдөлгөөн, хэвлэл мэдээллийн байгууллага, албад эрхгүй бодох цаг болжээ.

Суут хүмүүсийнхээ дурсгалыг мөнхжүүлэхэд пүүс компаниуд хөрөнгө санхүүгийн хувьд бололцооныхоо хирээр туслах боломж хангалттай бий. Гэвч дороос санаачилж дээрээс дэмжиж зохион байгуулах талаар боддог, сэддэг хүн одоохондоо тун ч цөөхөн байх мэт. Ер нь бид аль болгон урсгалаараа хөвөрч , өнөө маргаашаа аргацаах вэ? Хэдэн жилийн дараа тийм үр дүнд хүрэх ёстой хэмээн алсыг харсан ажил зохион байгуулах хэрэгтэй болжээ. Зарим нэгэн ажил эхэлж байвч үр дүн нь үзэгдэхгүй байна. 2001 оны дундуур хатагтай Насанжаргал хэмээгч Япон улсаас тусламж авч **“намтар судлалын төв”** байгууллаа хэмээн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж байсан. Гэвч уул төв ямар үйл ажиллагаа явуулж буй нь ер чимээгүй. Бидний бодоход түүхэн зүтгэлтний намтар судлалаар нилээд дорвитой ажил зохиох талаар ШУА , их дээд сургуулиуд санаачлага гаргах цаг болжээ.

ABSTRACT:

This paper addresses some aspects of the biography and legacies of Dogsomyn Bodoо, a prominent politician of the 20th century Mongolia, a well-educated cleric, a writer, a publicist, a teacher, and most importantly, the first Prime Minister of the People's Government (1921-22). The paper's research objective is to reveal some of the historiographic attitude on Bodoо, found in selected sources released after his false conviction and execution in 1922.

НОМ ЗҮЙ

1. АНУ-ын архивт буй Богд хаан, Бодоо нарын захидал-"Зууны мэдээ" сонин 2002-07-17 №173
2. Бадрах.Ө "Намаас баруун бөөрөнхийчүүд лүгээ тэмцсэн амжилттай их тэмцлийн туршлага" Хоёр дахь хэвлэл. *Шинэ үсэгт буулгаж хэвлэлд бэлтгэн тайлбар хийсэн Чу.Болдбаатар, На.Сүхбаатар. УБ. 2001*
3. Бат-Очир.Л "Бодоо сайд. Үзэл ба үйлс" УБ 1990
4. Бат-Очир.Л "Догсомын Бодоогийн талаар нэмэн өгүүлэх нь"- *Лхамсүрэнгийн Бат-Очир түүхийн үнэний эрэлд" (Судалгааны өгүүллтийн түүвэр УБ 1999) 318-345*
5. Болдбаатар.Ж "Догсомын Бодоо"- *Ж.Болдбаатар "Монгол Улсын Засгийн Газрын тэргүүн" УБ 2003 83-92*
6. "Догсомын Бодоо" Хэлсэн бичсэн зүйлийн түүвэр. *Эмхтгэж хэвлүүлсэн доктор проф Л.Бат-Очир УБ 2001*
7. Должингийн Мядагмаа 1993 оны 6-8-р сард З.Лонжидтой ярилцсан зүйлийн тэмдэглэл-зохиогчийн хувийн архив.
8. Дэлэг.Г "Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл" УБ 1965
9. МАХН-ын төв архив
10. Магсаржав.Н "Монгол улсын шинэ түүх" *Гар бичмэл эхээс кирилл бичгээр хэвлүүлсэн О.Батсайхан, З.Лонжид УБ 1994*
11. "Монгол-Зөвлөлтийн харилцаа" (1921-1974) Баримт бичиг материалын эмхтгэл.
I боть. 1921-1940 УБ 1976
12. "Монгол улсын түүх" тавдугаар боть(хх зуун) УБ 2003
13. "Монгол улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга Н.Сампилноровоос 1995 оны 6-р сарын 15-нд З.Лонжидод өгсөн 199 тоот албан бичиг-зохиогчийн хувийн архив"
14. Найдангийн Дулмаа 1991 оны 1-р сарын 8-нд З.Лонжидтой ярилцсан зүйлийн тэмдэглэл-зохиогчийн хувийн архив.
15. Партизан Д.Ээндэнданзангийн дуртгал-түүхч Отгоны Пүрэвийн хувийн архивт
16. "Уриа" сонин
17. Чойбалсан.Х, Лосол.Д, Дэмид.Г. "Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх". Хоёр дахь хэвлэл. *Монгол бичгээс кирилл бичигт буулгаж хэвлүүлсэн Д.Даш. УБ 1979.*
18. Эрдэнэбат.Г "Д.Бодоог 75 жилийн дараа цагаатгалаа"-*"Ардын эрх" сонин 1997-06-16 №135*